



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 88

танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Авлагын дансны үлдэгдэлд 28.7 сая төгрөгийн тооцооны үлдэгдлийн баталгааны баримтаар баталгаажаагүй авлага бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос өсөхөд нүүрс, мазут, үндсэн сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал нөлөөлсөн ба бараа материалын үлдэгдэлд өртөг нь бодит үнэ цэнээс бага 3.8 сая төгрөгийн техник, технологид нийцэх эсэх тодорхойгүй түүхий эд материал бүртгэлтэй байна.

Шинээр 2,243.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 2,578.9 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр угсарч суурилуулж, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 33.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 48.6 сая төгрөгийн тавилга эд хогшил акталсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 12,264.3 сая төгрөг болж өссөн ба тооцооны үлдэгдлийн баталгааны баримтаар баталгаажсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 16,223.9 сая төгрөгөөр өссөн нь шинэ өргөтгөл ажиллаж эхэлсэн болон дулааны эрчим хүчний түгээлт 11.8 мянган Гкал-аар нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын гол асуудал

Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хөнгөлөлттэй зээлээр барьсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх 126,286.5 сая төгрөгийн өргөтгөлийн ажил дуусаж, улсын комисс хүлээн авч, ашиглаж эхэлсэн боловч хөрөнгийг бүртгэх, зээлийн төлөлтийн талаарх шийдвэрийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар гаргаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 58,879.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 71,556.0 сая төгрөгөөр, 12,676.8 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоож, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 10,735.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2022 оны А/189 дүгээр тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг тодотгохдоо нийт орлогыг 784.0 сая төгрөг нэмж, нийт зардлыг 607.6 сая төгрөг, алдагдлыг 1,391.6 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 305.5 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 62,860.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 66,192.3 сая төгрөгийн зардал гарган, 3,661.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 3 нэр төрлийн 136 ажилд өөрийн эх үүсвэрээс 10,182.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ